



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/165

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт  
оруулж, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 2 иргэний гаргасан хүсэлтийн дагуу 0.2427га (2427м<sup>2</sup>) газрын газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т үүрэг болгосугай

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дүгээр сарын 17-ны өдрийн  
А/165 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ  
ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Иргэдийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Газар эзэмшүүлэх хугацаа	Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	Тэс овгийн Баярсүрэн Баасансүрэн (РС82032611)	6712017518	13-р баг Баян-Эрхэт-8 807 тоот	27	Сумын Засаг даргын 2010.02.09-ний өдрийн №15 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 1 дэх хэсгийн 8 дахь баганын талбайн хэмжээг "464м <sup>2</sup> " гэснийг "780м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /мэдээллийн сан/
2	Харнууд овгийн Гүндсамбуу Мягмарсүрэн (ХЛ59030204)	Шинээр	8-р баг Дамдинбазар-1 111 тоот	18	Аймгийн Засаг даргын 2019.10.31- ний өдрийн А/478 дугаар захирамжийн хавсралтын 2 дахь хэсгийн 7 дахь баганын талбайн хэмжээг "1562м <sup>2</sup> " гэснийг "1647м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /хэмжилтээр/ 6712008280 нэгж талбарын дугаартай

Нийт талбайн хэмжээ-2427м<sup>2</sup>

-----оОо-----

